## ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТ СУРТАЧИЛГАА

1. “Антибиотикийн зохистой хэрэглээ” 1 сарын аян зохион байгуулж аяны хүрээнд өдөрлөгийн үйл ажиллагааг 1 удаа, 56 удаагийн сургалт сурталчилгааг малчид, хэвтэн эмчлүүлэгчид, ард иргэд, сургуулийн сурагчдад хийлээ. Сургалтын өмнөх болон сургалтын дараах иргэдийн мэдлэгийн түвшний ахиц, хандлагын байдалд үнэлгээ өгч ажилласан ба иргэдийн мэдлэг дундажаар 21,2%-иар нэмэгдсэн байна.








2. Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, иргэдийн эмийн зохистой хэрэглээний мэдлэг хандлагыг сайжруулах зорилготой мэдээллийн өдөрлөгийн үйл ажиллагааг БОЭТ-ийн эм зүйн алба, аймгийн төвийн эмийн сангуудтай хамтран зохион байгууллаа.













3. Дэлхийн эм зүйчийн өдөрт зориулсан үйл ажиллагааны төлөвлөөний дагуу Оюутанд зөвлөн туслах өдөрлөгийн үеэр политехникийн коллежийн оюутнуудад 1 удаа сургалт хийж, сургалтын дараа мэдлэг сорих АХА хөгжөөнт тэмцээнийг хийлээ.




4. Даланзадгад сумын багууд дээр Хөдөлгөөнт багийн үйл ажиллагааны үеэр Антибиотикийн зохистой хэрэглээ, Эмийн гаж нөлөө, нянгийн тэсвэржилт, хор уршиг сэдвээр 612 иргэнд сургалт мэдээллийг хүргэсэн.
   - Төрийн үйлчилгээ авч буй иргэдээс түүвэрлэн 47 иргэнээс антибиотикийн зохистой хэрэглээний мэдлэг хандлагын тандалтын асуумж судалгаа авч дүгнэсэн байна.





Өмнөговь оны эм зүйн үзүүлэлт - **2019 он**











5. Эрүүл мэндийн газрын зүгээс Эрүүл Өмнөговьчууд цахим хуудсаар цуврал байдлаар антибиотикийн зохистой хэрэглээний видео мэдээллийг оруулсан.












**Эрүүл Өмнөговьчууд**
September 11 at 2:35 PM ·

**Өмнөговь аймаг Эрүүл Мэндийн газар**
September 11 at 10:33 AM ·

АНТИБИОТИКИЙГ БУРУУ ХЭРЭГЛЭЭНИЙ ХОР ХӨНӨӨЛ
Хүний биед орсон өвчин үүсгэгч нян... See More



123 Views

**Өмнөговь аймаг Эрүүл Мэндийн газар**
September 17 at 5:33 PM ·

АНТИБИОТИКИЙГ ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ
Хэрвээ ямар нэгэн антибиотик танд тохирдаггүй бол эмчид үзүүлэхдээ заавал хэлээрэй.
Тухайн антибиотикийг уух боломжтой үед хэзээ ч тариагаар бүү хэрэглээрэй. Зөвхөн шаардлагатай үед л тариагаар хэрэглээрэй.
Антибиотикийг ялангуяа хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхэд маш болгоомжтой хэрэглээрэй. Учир нь тетрациклин, левомицетин зэрэг антибиотик нь хүүхэд болон урагт хортой нөлөө үзүүлдэг. Хэрвээ антибиотик хэрэглэмэгц арьс улайж тууралт гарах, загатнах, амьсгал давчдах, болон харшлын ямар нэг шинж илэрвэл, хэрэглэхээ зогсоож эмчдээ даруй мэдэгдээрэй.



Дэлхийн эм зүйч нарын өдөрт зориулж 49 эм хангамжийн байгууллагын эмийн мэргэжилтнүүдийн зүгээс “Антибиотикийг жороор олгоно уриалгыг гаргаж батламжилсан.

